



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/24/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улаангай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЯРУУ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ЭРДЭНЭНЭМЭХ-Д

додд. ос. дг № 1302/464
талай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Яруу сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Яруу сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний хяналт хангалтгүй байдалтай холбоотой алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал батлагдсан төсвийн гүйлгэн зарцуулалтад хяналт тавиаагүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн, төлбөрийн хүсэлтэд эрх бүхий алба хаагчид гарын үсэг зурж баталгаажуулаагүй байхад гүйлгээ хийсэн байна. Мөн орон нутгийн төсвийн орлогоос сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал хариуцан барагдуулах ажлаас халагдсан алба хаагчийн цалинг олгосон зэрэг зөрчлүүд нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага

013025599

хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	437,072,850.06	557,702,518.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	57,638,253.35	180,345,216.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	57,638,253.35	180,345,216.62
3121	Төгрөг	57,638,253.35	180,345,216.62
31211	Төрийн сангийн харилцах	57,638,253.35	180,345,216.62
33	АВЛАГА	187,302,601.90	190,837,322.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	769,340.02	2,007,376.28
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		14,784,000.00
335	Бусад авлага	186,533,261.88	174,045,945.88
3351	Байгууллагаас авах авлага	2,206,329.88	4,195,833.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	184,326,932.00	169,850,112.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал		0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	192,131,994.81	186,519,979.70
351	Түүхий эд материал	16,851,293.37	32,125,073.37
35110	Тусгай зориулалттай материал	5,980,664.00	5,980,664.00
35130	Эм боох материал	10,870,629.37	26,144,409.37
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,790,190.00	3,218,200.00
354	Хангамжийн материал	172,490,511.44	151,176,706.33
35410	Бичиг хэргийн материал	8,253,908.80	9,819,746.80
35420	Аж ахуйн материал	105,020,641.64	105,947,500.53
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	272,266.00
35440	Түлш, шатах тослох материал	26,620,349.00	9,194,200.00
35450	Барилгын засварын материал	1,813,800.00	2,005,000.00
35460	Хүнсний материал	15,949,789.00	10,848,298.00
35470	Бусад хангамжийн материал	14,832,023.00	13,089,695.00
35600	Мал амьтад	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,564,925,985.10	1,585,539,796.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,564,925,985.10	1,585,539,796.69
392	Биет хөрөнгө	1,440,863,135.10	1,462,871,946.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,581,767,822.50	1,577,840,802.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	344,117,153.97	390,828,681.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	184,700,550.00	184,700,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	132,852,630.26	146,431,589.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	375,646,684.94	473,285,081.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	322,543,614.56	333,657,860.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,640,728.27	147,738,500.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	104,583,193.05	115,177,233.22
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	83,346,236.50	85,925,136.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	53,278,310.15	51,119,624.87
39217	Ном	30,136,014.88	30,596,865.88
393	Биет бус хөрөнгө	124,062,850.00	122,667,850.00
39301	Програм хангамж	8,867,000.00	8,867,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,530,750.00	4,925,750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	118,726,600.00	118,726,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,001,998,835.16	2,143,242,315.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	876,031.00	2,122,894.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	876,031.00	2,122,894.00
413	Өглөг	876,031.00	2,122,894.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	816,031.00	1,477,356.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4136	Бусад өглөг	60,000.00	645,538.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60,000.00	645,538.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,001,122,804.16	2,141,119,421.17
51	Засгийн газрын хувь оролцоо	2,001,122,804.16	2,141,119,421.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,155,612,596.69	1,155,612,596.69
51101	Өмч: - төрийн	1,155,612,596.69	1,155,612,596.69
512	Хуримтлагдсан үр дүн	266,129,435.88	412,681,652.89
51210	Өмнөх үеийн үр дүн	70,736,555.35	272,582,232.54
51220	Тайлант үеийн үр дүн	195,392,880.53	140,099,420.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,380,771.59	572,825,171.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,001,998,835.16	2,143,242,315.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,562,950,377.70	2,453,510,727.67
11	ТАТВАРЫН ОРЛОГО	55,993,481.40	160,281,166.31
110	Орлогын албан татвар	41,206,277.50	38,820,933.81
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,206,277.50	38,820,933.81
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	11,357,616.00	2,340,874.00
110002	Үйл ажиллагааны орлого	28,698,785.50	35,880,059.81
110008	Шууд бус орлого	1,149,876.00	600,000.00
113	Хөрөнгийн албан татвар	3,388,000.00	45,220,012.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	100,000.00	3,536,000.00
113002	Бууны албан татвар	3,288,000.00	3,534,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		38,150,012.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	11,399,203.90	76,240,220.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,465,100.00	3,212,370.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	710,100.00	1,522,370.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	450,000.00	810,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	305,000.00	880,000.00
1181	Газрын төлбөр	350,304.00	1,365,031.00
118101	Газрын төлбөр	350,304.00	1,365,031.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,669,770.00	71,662,819.50
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	4,387,220.00	4,331,387.50
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,550.00	67,205,432.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	120,000.00	126,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	160,000.00	
1183	Бусад татвар	4,914,029.90	0.00
118301	Бусад татвар	4,914,029.90	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419,074,104.51	139,397,550.46
120	Нийтлэг татварын бус орлого	419,074,104.51	139,397,550.46

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

120002	Хүүгийн орлого	26,499,956.14	30,341,990.40
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,574,148.37	109,055,560.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,990.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	392,574,148.37	109,049,570.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,087,882,791.79	2,153,832,010.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	971,760,500.00	987,497,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	971,760,500.00	987,497,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,211,018.00	70,899,559.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,100,218.00	28,588,744.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,110,800.00	42,310,815.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,056,758,833.79	1,026,872,941.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	573,094,500.00	515,806,300.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	2,889,140.79	6,249,854.90
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	446,213,000.00	435,999,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	34,562,193.00	68,816,887.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,152,440.00	68,562,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,152,440.00	68,562,310.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,322,978,897.17	2,233,348,521.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,322,978,897.17	2,233,348,521.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,662,834,970.38	1,650,382,577.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,077,742,907.50	1,116,760,546.84
210101	Үндсэн цалин	865,547,762.00	855,875,967.84
210102	Нэмэгдэл	128,298,553.00	178,268,812.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,516,750.00	3,750,000.00
210104	Урамшуулал	62,635,297.00	63,052,004.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,744,545.50	15,813,763.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,924,441.53	142,562,481.00
210201	Тэтгэврийн даатгал	90,082,655.71	103,362,055.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,896,769.82	10,168,332.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,535,929.00	8,200,386.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,946,300.00	1,872,742.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,462,787.00	18,958,966.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,102,564.00	85,318,315.00
210301	Гэрэл, цахилгаан	8,552,528.00	8,598,462.00
210302	Түлш, халаалт	66,904,336.00	75,057,853.00
210303	Цэвэр, бохир ус	1,645,700.00	1,662,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,084,486.00	69,924,099.11
210401	Бичиг хэрэг	6,013,810.00	6,262,610.00
210402	Тээвэр, шатахуун	39,181,656.00	39,635,200.00

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,764,000.00	5,701,700.00
210404	Ном, хэвлэл	35,400.00	257,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,510.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,853,110.00	3,820,472.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	14,246,717.11
2105	Нормативт зардал	53,090,231.00	61,665,471.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,215,100.00	39,602,425.00
210502	Хоол, хүнс	27,825,131.00	22,063,046.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,580,710.00	10,608,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320,000.00	0.00
210604	Урсгал засвар	22,260,710.00	10,608,700.00
2107	Томилолт, зочны зардал	6,465,200.00	5,773,500.00
210702	Дотоод албан томилолт	6,465,200.00	5,773,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,100,817.00	28,341,334.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,456,493.00	25,032,124.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	842,100.00	2,046,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	295,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	36,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	996,400.00	153,400.00
210807	Газрын төлбөр	31,492.00	82,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,732.00	5,110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,743,613.35	129,428,130.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,563,640.00	24,577,911.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,589,150.00	2,673,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,590,823.35	102,176,419.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	660,143,926.79	582,965,943.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,480,044.00	43,731,599.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,670,200.00	7,246,015.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,977,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,332,044.00	8,607,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	27,878,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,125,799.00	1,300,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,125,799.00	1,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	575,983,640.79	525,956,154.90
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	573,094,500.00	515,806,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,889,140.79	10,149,854.90

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,554,443.00	11,978,190.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,554,443.00	11,978,190.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	239,971,480.53	220,162,205.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	44,571,600.00	80,062,785.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	44,571,600.00	80,062,785.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-44,571,600.00	-80,062,785.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	195,399,880.53	140,099,420.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,150,468,796.69	579,380,771.59	70,736,555.35	1,800,586,123.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,143,800.00			5,143,800.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,155,612,596.69	579,380,771.59	70,736,555.35	1,805,729,923.63
C07	Тайлант үеийн үр дүн			195,392,880.53	195,392,880.53
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,155,612,596.69	579,380,771.59	266,129,435.88	2,001,122,804.16
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,155,612,596.69	579,380,771.59	266,129,435.88	2,001,122,804.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-6,555,600.00	6,452,796.66	-102,803.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,155,612,596.69	572,825,171.59	272,582,232.54	2,001,020,000.82
D08	Тайлант үеийн үр дүн			140,099,420.35	140,099,420.35
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,155,612,596.69	572,825,171.59	412,681,652.89	2,141,119,421.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,230,815,167.33	2,366,080,174.27
11	ТАТВАРЫН ОРЛОГО	56,016,481.40	159,681,166.31
110	Орлогын албан татвар	41,206,277.50	38,220,933.81
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,206,277.50	38,220,933.81
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	11,357,616.00	2,340,874.00
110002	Үйл ажиллагааны орлого	28,698,785.50	35,880,059.81
110008	Шууд бус орлого	1,149,876.00	
113	Хөрөнгийн албан татвар	3,388,000.00	45,220,012.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	100,000.00	3,536,000.00
113002	Бууны албан татвар	3,288,000.00	3,534,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		38,150,012.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	11,422,203.90	76,240,220.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,465,100.00	3,212,370.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	710,100.00	1,522,370.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	450,000.00	810,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	305,000.00	880,000.00
1181	Газрын төлбөр	350,304.00	1,365,031.00
118101	Газрын төлбөр	350,304.00	1,365,031.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,692,770.00	71,662,819.50
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	4,387,220.00	4,331,387.50
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	25,550.00	67,205,432.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	120,000.00	126,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	160,000.00	
1183	Бусад татвар	4,914,029.90	0.00
118301	Бусад татвар	4,914,029.90	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,915,894.14	65,850,997.06
120	Нийтлэг татварын бус орлого	86,915,894.14	65,850,997.06
120002	Хүүгийн орлого	20,982,135.14	21,266,261.25
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,933,759.00	44,578,745.81
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,933,759.00	44,578,745.81
120009	Бусад орлого	0.00	5,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,087,882,791.79	2,140,548,010.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	971,760,500.00	987,497,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	971,760,500.00	987,497,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,211,018.00	105,832,969.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,100,218.00	62,022,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,110,800.00	43,810,815.00

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,056,758,833.79	1,026,872,941.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	573,094,500.00	515,806,300.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	2,889,140.79	6,249,854.90
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	446,213,000.00	435,999,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	34,562,193.00	68,816,887.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,152,440.00	20,344,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,152,440.00	20,344,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,142,257,958.00	2,110,358,211.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,142,257,958.00	2,110,358,211.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,478,998,641.21	1,528,575,312.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,077,383,773.95	1,114,009,358.10
210101	Үндсэн цалин	806,520,051.45	756,316,631.10
210102	Нэмэгдэл	180,994,395.00	246,051,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,466,750.00	8,041,803.00
210104	Урамшуулал	65,628,034.00	87,318,332.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,774,543.50	16,280,792.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,414,829.26	143,104,300.00
210201	Тэтгэврийн даатгал	91,468,713.00	98,865,129.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,865,010.00	12,898,774.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,450,579.00	8,663,213.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,029,169.26	2,064,228.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,601,358.00	20,612,956.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,868,709.00	75,608,536.00
210301	Гэрэл, цахилгаан	8,656,109.00	9,784,832.00
210302	Түлш, халаалт	62,236,900.00	64,161,704.00
210303	Цэвэр, бохир ус	1,975,700.00	1,662,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,751,065.00	52,825,460.00
210401	Бичиг хэрэг	5,777,000.00	6,883,860.00
210402	Тээвэр, шатахуун	38,453,055.00	34,401,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,666,200.00	5,771,700.00
210404	Ном, хэвлэл	81,000.00	257,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	708,100.00	645,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,065,710.00	4,865,400.00
2105	Нормативт зардал	57,393,871.00	64,350,558.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,481,971.00	37,384,262.00
210502	Хоол, хүнс	26,335,000.00	22,213,096.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,576,900.00	4,753,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,228,400.00	12,950,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	687,000.00	809,000.00

Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320,000.00	344,500.00
210604	Урсгал засвар	20,221,400.00	11,796,900.00
2107	Томилолт, зочны зардал	6,465,200.00	5,773,500.00
210702	Дотоод албан томилолт	6,465,200.00	5,773,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,807,553.00	29,324,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,916,329.00	25,965,075.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	642,100.00	2,046,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,800.00	295,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	36,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,253,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	81,492.00	82,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,732.00	5,110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,685,240.00	30,628,915.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,638,640.00	23,296,315.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,046,600.00	7,332,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	663,259,316.79	581,782,898.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,595,434.00	42,548,554.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,785,590.00	5,862,970.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,977,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,332,044.00	8,607,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	28,078,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	579,109,439.79	527,256,154.90
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	573,094,500.00	515,806,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,889,140.79	10,149,854.90
213404	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх	3,125,799.00	1,300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,554,443.00	11,978,190.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,554,443.00	11,978,190.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	88,557,209.33	255,721,963.27
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	69,626,600.00	112,165,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,626,600.00	112,165,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	69,626,600.00	112,165,000.00
223001	Бусад хөрөнгө	44,571,600.00	77,625,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,055,000.00	34,539,200.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-69,626,600.00	-112,165,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-64,920,200.00	-20,850,000.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-64,920,200.00	-20,850,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-64,920,200.00	-20,850,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-45,989,590.67	122,706,963.27
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103,627,844.02	57,638,253.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,638,253.35	180,345,216.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,687,733,200.00	1,579,425,240.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,534,708,200.00	1,504,330,440.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,524,764,700.00	1,496,988,970.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,299,200.00	1,093,687,253.10
210101	Үндсэн цалин	803,434,000.00	756,316,631.10
210102	Нэмэгдэл	208,798,800.00	246,051,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,307,000.00	8,041,803.00
210104	Урамшуулал	65,958,600.00	66,996,227.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,800,800.00	16,280,792.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,108,300.00	143,104,300.00
210201	Тэтгэврийн даатгал	104,928,300.00	98,865,129.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,045,100.00	12,898,774.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,835,900.00	8,663,213.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,209,000.00	2,064,228.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,090,000.00	20,612,956.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,708,000.00	76,068,536.00
210301	Гэрэл, цахилгаан	10,376,000.00	9,784,832.00
210302	Түлш, халаалт	64,196,300.00	64,161,704.00
210303	Цэвэр, бохир ус	2,135,700.00	2,122,000.00

**Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	53,522,000.00	52,560,100.00
210401	Бичиг хэрэг	6,640,700.00	6,640,700.00
210402	Тээвэр, шатахуун	33,686,800.00	33,577,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,738,300.00	6,054,200.00
210404	Ном, хэвлэл	685,600.00	625,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,200.00	645,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,125,400.00	5,016,500.00
2105	Нормативт зардал	49,166,800.00	41,319,396.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,372,700.00	17,372,700.00
210502	Хоол, хүнс	27,206,900.00	19,359,996.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,587,200.00	4,586,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,112,500.00	19,095,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	818,800.00	809,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	344,500.00	344,500.00
210604	Урсгал засвар	17,949,200.00	17,941,900.00
2107	Томилолт, зочны зардал	6,546,700.00	5,701,500.00
210702	Дотоод албан томилолт	6,546,700.00	5,701,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,095,600.00	24,247,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,354,500.00	21,019,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,915,300.00	1,915,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	295,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	36,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	188,300.00	82,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,700.00	5,110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450,000.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,205,600.00	41,204,815.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,109,000.00	19,108,915.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,096,600.00	22,095,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,943,500.00	7,341,470.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,943,500.00	7,341,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,465,000.00	5,862,970.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,478,500.00	1,478,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,025,000.00	72,949,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	73,025,000.00	72,949,800.00
223001	Бусад хөрөнгө	73,025,000.00	72,949,800.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,000,000.00	2,145,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	80,000,000.00	2,145,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,687,733,200.00	1,618,815,987.91

Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	987,231,200.00	975,519,010.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	987,231,200.00	975,519,010.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	549,340,700.00	578,373,332.10
132001	Орон нутгийн төсвөөс	480,451,000.00	509,556,445.10
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	68,889,700.00	68,816,887.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,344,900.00	20,344,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,344,900.00	20,344,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,816,400.00	44,578,745.81
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,816,400.00	44,578,745.81

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,318,626.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,642,626.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,135,542.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,332,105.00
210104	Урамшуулал	20,332,105.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,729,860.00
210401	Бичиг хэрэг	243,160.00
210402	Тээвэр, шатахуун	824,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	662,700.00
2105	Нормативт зардал	23,031,162.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,011,562.00
210502	Хоол, хүнс	2,853,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,500.00
2107	Томилолт, зочны зардал	238,500.00
210702	Дотоод албан томилолт	238,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,241,615.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,110,815.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	130,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,562,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,980,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,581,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,207,084.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,607,084.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,300,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,676,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,676,000.00
223001	Бусад хөрөнгө	4,676,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105,832,969.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,832,969.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,022,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,810,815.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлээгүй байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэн орон нутагтаа их бүтээн байгуулалт хийж, хөгжил дэвшилд хүргэх гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэх

- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлэх
- Хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй сум болох
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах
- Нийгмийн амар тайван байдлыг хангах
- Эрсдэлгүй, өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйг хөгжүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 2,366.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 35.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 26.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 180.3 сая төгрөг болж өмнөх оноос 122.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 10.5 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 67.2 сая төгрөг нь СХС-ийн, 52.6 сая төгрөг нь ОНХС-ийн, 418.1 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлага дансны үлдэгдэл 178.7 сая төгрөг болж өмнөх оноос 37.4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд үүссэн авлага, сум хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЗДТГ	-	76,051.00
ИТХ	223,857.00	1,872,945.28
ЭМТ	3,377,354.90	20,238,833.88
Сургууль	482,035.00	58,380.00
Цэцэрлэг	22,423.00	-
СХС	183,196,932.00	168,591,112.00
ДҮН	187,302,601.90	190,837,322.16

Илрүүлэлт: ТШЗ-ын аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 16.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 186.5 сая төгрөг болж өмнөх оноос 5.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэн, өмнөх оны үлдэгдлийн зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,585.5 сая төгрөг болж өмнөх оноос 20.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь элэгдлийн зардал, болон хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

Өглөг

Өглөгийн дүн 2.1 сая төгрөг болж өмнөх оноос 1.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хүүхдийн цэцэрлэгт бий болсон байна.

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 2,141.1 сая төгрөг болж өмнөх оноос 140.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 1,661.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 25.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,687.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт нэмж тодотгол хийсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,687.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,534.7 сая төгрөгийг урсгал зардалд, 73.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 80.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 987.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 480.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 68.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 72.3 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 58.5 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 987.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 515.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 20.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 68.8 сая төгрөг, нийт 1,592.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 95.3 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 44.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 27.7 сая төгрөгөөр тасарсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байна гэж үзлээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,598.7 сая төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн, санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 10.1 сая төгрөгийг сумын төсөвт, 12.0 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 62.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 43.8 сая, нийт 105.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 99.6 сая төгрөгийг, 4.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж үлдэгдэл 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 129 мэдээллээс 126 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Яруу сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 3.0 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 46.3 сая төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй байна.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.2.3 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан хугацааны цалин нөхөн олгосон 3.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаагүй, гүйлгэн зарцуулсан, байгууллагын бүх ажилчид, албан хаагчдад албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авсан, хүүхдийн баярын бэлгийг төсвөөс зарцуулж, зориулалт бус худалдан авалт хийсэн, эмийн зардлаас "Содон урлахуй" ХХК руу шилжүүлсэн үнийн дүнгийн үндсэн баримтгүй, төлбөрийн хүсэлтгүй, уг компанид шилжүүлсэн мөнгөөр ажилчдад биеийн тамирын хувцас худалдан авч олгосон, холбогдох байгууллагын шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар анхан шатны баримтгүй, гарын үсэг, тэмдэггүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллаж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: ТШЗ-ийн санхүүгийн тайланг зөрүүтэй нэгтгэсэн 0.1 сая төгрөгийн алдаа илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах; 54 дүгээр зүйлийн 54.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана гэсэн заалтууд болон толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Соёлын төв байгууллагын Э-тайланд аудитаар баталгаажуулсан тайлантай тулган хагас жилийн санхүүгийн тайлангаар залруулга хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	10	69.3			3	1.3	4	55.0	3	13.0
2	Эрүүл мэндийн төв	10	206.3	3	13.6	3	16.3	1	166.9	3	9.6
3	Хүүхдийн цэцэрлэг	4	10.5			1	1.9			3	8.6
4	Ерөнхий боловсролын сургууль	5	14.2	1	0.3					3	13.4
5	Соёлын төв	2	6.4	1	4.1					1	2.3
6	ОНХС	3	9.4							3	9.4
7	ИТХ	3	2.7			1	0.4			2	2.3
8	Төвлөрүүлэн захирагч	3	49.3					1	3.0	2	46.3
Дүн		40	368.0	5	17.9	9	20.3	6	224.9	20	104.9

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

